

# ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар											
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			13			
Уулзалтын №		77			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			11			
Огноо		2018 оны 5 сарын 31			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			тийм			
ХУРЛЫН ДАРГА											
Нэр/ Байгууллага		Овог		Бямбасүрэн			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)			4.30	
		Нэр		Мягмар			Хурал зохион байгуулагдсан газар			Скай Плаза, хурлын А танхим	
		Байгууллага		МУЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга							
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Тохирох бөглөнө үү)		Дарга		x		Уулзалтын төрөл (Тохирох нүдийг бөглөнө үү)		Ээлжит		X	
		Дэд дарга						Ээлжит бус			
		Гишүүн						Хорооны уулзалт			
		Гишүүнийг орлогч				Бусад байгууллагын оролцоо (Тохирох нүдийг бөглөнө үү)		СОНА		X	
Салбар * (Тохирох нүдийг бөглөнө үү)											
ЗГ		ОУБ		ТББ		Боловсрол		Өвчлөлт бүлгийн хүн ам		Эрдэлт бүлгийн хүн ам	
										Шашны Байгууллага	
										Хувийн Хэвшил	
										x	
										бусад	
										X	
										өрөлцөөгүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүдийг бөглөнө үү)													
ҮЗЗ-ИЙН ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД													
Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хянах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйтний эрх тэгш байдал	Төсөл боловсруулах	УХА, СХА	Тэтгэлэг	Ханалт (улирлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II үе/, хаалт	Техникийн туслацаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах	x											
Хөтөлбөр #2	ҮЗЗ-ийн дүрмийг хэлэлцэн эцэслэн батлах, ҮЗЗ-ийн дарга, дэд дарга	x		x	x	x	x	x	x				x
Хөтөлбөр #3	Төсөл хөтөлбөрүүдийн дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл хийх:	x					x				x		

Хөтөлбөр	
№.	Хөтөлбөрийг дурдана уу
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах
Хөтөлбөр #2	ҮЗЗ-ийн дүрмийг хэлэлцэн эцэслэн батлах, ҮЗЗ-ийн дарга, дэд дарга
Хөтөлбөр #3	Төсөл хөтөлбөрүүдийн дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл хийх:

Хөтөлбөр #4	2018-2020 онд хэрэгжүүлэх төслүүдийн Санхүүжилтийн баталгааны болзолт нөхцлүүд	x						x	x									
Хөтөлбөр #5	Эрүүл мэндийн салбарын засаглалыг бэхжүүлэх хүрээнд ХДХВ, сүрьеэгийн төслийг нэгдсэн зохицуулалтаар хангах техникийн туслалцаа, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардлагатай төсвийн төслийг боловсруулах												x				x	x
Хөтөлбөр #6	Салбар хүлээн авагчийн танилцуулга: ХӨСҮТ-ийн Сүрьеэ болон БЗДХ-ийн ТСА-ны төслүүдийн хэрэгжилтийн танилцуулга	x																x

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл			
<b>Хөтөлбөр #1</b>	<b>Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт</b>		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>			үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
<b>Б.Мягмар:</b> ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүд саналгүй тул хөтөлбөрийг батлав. 2018 оны 5 сарын 18-нд хуралдах байсан хурлыг хойшлуулах болсондоо нийт гишүүд, хамтран ажиллагаагаас хүлцэл өчөөд, хүлээн авч дэмжин өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэнд нь талархал илэрхийлэв. ҮЗЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд шинэ гишүүд нэмэгдсэн тул хуралд оролцогчид өөрсдийгөө танилцуулав. 77 дах хурлын шийдвэрийн биелэлтийг <b>ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь</b> танилцуулав.			
76 дахь удаагийн хурал 2018 оны 3 сарын 13-нд болсон.			
хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	Гүйцэтгэл
хөтөлбөр#2	1.ҮЗЗ-ийн гишүүн бүр 2018 оны 3 сарын 20-ны өдөр гэхэд ҮЗЗ-ийн дүрмэн дээрх өөрсдийн саналыг Ажлын албанд цахимаар тайлбарлан ирүүлэх шаардлагатай бөгөөд хэрэв дүрэм дээр ямар нэг саналгүй бол саналгүй гэсэн мэдэгдэл явуулах шаардлагатай гэсэн үүргийг ҮЗЗ-ийн нийт гишүүдэд өглөө. 2.Дүрмийн ажлын хэсгийн гишүүн Ц.Ганхүү саналаараа ажлын хэсгийг орхиж, Төрийн байгууллагын төлөөлөл НЭМГ-ын дарга Д.Ганцэцэг ажлын хэсэгт орж, ХЗН арга зүйн дэмжлэг үзүүлэн, ҮЗЗ-ийн Ажлын Албаны ажилчид энэхүү дүрмийн гишүүдийн ирүүлсэн санал болон бусад холбогдох материалууд дээр ажлын хэсэгтэй хамтран ажиллахаар шийдвэрлэн ҮЗЗ-ийн ээлжит 77 дахь хурлаар шинэчилсэн дүрмийг батлах ажлыг дахин хэлэлцэхээр гишүүдийн олонхийн саналаар баталлаа	АЖЛЫН АЛБА, ҮЗЗ-ийн гишүүд	90%
хөтөлбөр#4	СХА-чдын хурлыг зохион байгуулахын оронд ҮЗЗ-ийн ээлжит хурлуудаар СХА-дыг урьж оролцуулан хийж буй ажлаа танилцуулан ҮЗЗ-ийн шинэ гишүүдэд мэдээлэл өгөх байдлаар зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналыг тусгахыг хүсэн ҮЗЗ-ийн 2018-2019 оны ажлын төлөвлөгөөг гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.	АЖЛЫН АЛБА, СХА	100%

хөтөлбөр#5	<p>ҮЗЗ-ийн Хяналтын хорооны бүтэц болон даргын тухай асуудлыг дараагийн 77 дах хурал дээр шийдвэрлэхээр хойшлууллаа. Энэхүү хуралд ирэхдээ ЭМЯ-ны зүгээс ЭМ-ийн дэд сайд, ТНБД, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нарын аль нэгийг оруулах тал дээр хуралдан хурлын шийдвэрийг авч ирэхээр боллоо.</p>		ЭМЯ, ҮЗЗ	100%
<b>Хөтөлбөр #2</b>	<ul style="list-style-type: none"> <li>• ҮЗЗ-ийн дүрмийг хэлэлцэн эцэслэн батлах,</li> <li>• ҮЗЗ-ийн дарга, дэд дарга</li> <li>• ҮЗЗ-ийн Хяналтын Хорооны бүтэц</li> </ul>			
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.				
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тгйм эсвэл үгүй)>				
				Тгйм
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй				
<p><b>А.Нямдорж:</b> Дүрмийн ажлын хэсгийн ахлагч А.Нямдорж ҮЗЗ-ийн дүрмийг уншиж танилцуулсан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан хэсгүүдийг тодотгон тайлбарлалаа. ҮЗЗ-ийн гишүүн Д.Ганчимэгтэй хамтран дүрмийг Монгол улсын хуульд нийцүүлэн, агуулга бичилтийн хувьд сайжруулсан болохыг мэдэгдэв. <i>/Хавсралт 1-Гишүүдийн саналыг тусгасан дүрэм /</i> Бүлэг бүр дээр гишүүд хэлэлцэн тохиролцож, санал хурааснаар дүрмийг гишүүд нэгдсэн байдлаар олонхийн саналаар нэгтгэн баталлаа.</p> <p><b>Б.Мягмар:</b> ЭМ Сайдын 1а/2182 тоот албан бичгийг хүлээн авсан бөгөөд үүнд ҮХА-г төлөөлж Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтбаатар, Нийгмийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Галбадрах нарын нэрийг ирүүлсэн. Энэ талаар Л.Бямбасүрэн даргын оронд ирсэн эсэхийг тодорхой болгож өгнө үү. Энэхүү албан бичгийн дагуу бид ҮЗЗ-ийн бүрэлдэхүүнд зохих өөрчлөлтүүдийг хийх бөгөөд дараагийн хурал дээр бүтэц, бүрэлдэхүүний талаархи асуудлыг хэлэлцэх саналыг гаргаж байна.</p>				
ТБ	<b>Б.Цогтбаатар:</b> ҮЗЗ-ийн дүрмийн дагуу нэр дэвшсэн 2 гишүүн өмнөх гишүүдийн оронд ҮЗЗ-ийн гишүүн болж орж ирсэн.			
Шийдвэр:				
<ol style="list-style-type: none"> <li>1. Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар ҮЗЗ-ийн дүрмийг бүлэг бүлгээр нь хэлэлцэн, санал хурааж эцэслэн баталлаа.</li> <li>2. Түүнчлэн ҮЗЗ-ийн дарга, дэд дарга, хяналтын хорооны бүтэц бүрэлдэхүүний асуудлыг ҮЗЗ-ийн 78 дахь удаагийн хурлаар эцэслэн шийдвэрлэхийг гишүүдийн саналаар түр хойшлуулав.</li> </ol>				
<b>Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар</b>				
Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүднийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		13
		Эсрэг>		
				Санал өгөхөөс түдгэлзэх

<b>Хөтөлбөр #3</b>	<b>Төсөл хөтөлбөрүүдийн дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл хийх:</b>			
<ul style="list-style-type: none"> <li>• Эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах тухай ЭМС-ын А/126 дугаар тушаал</li> </ul>				
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.				
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тгйм эсвэл үгүй)>				
				Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй				

Эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах тухай ЭМС-ын А/126 дугаар тушаалыг /Хавсралт 2/ ЭМЯ-ны мэргэжилтэн **А.Өнөржаргал** танилцууллаа /Танилцуулга-Хавсралт 3/. Та бүхнийг энэхүү тушаалуудтай танилцаад ЭМС-ын тушаалыг дэмжсэн шийдвэр гаргана гэж найдаж байна. Энэ үйл ажиллагааг ЭМЯ-ны зүгээс дахин төлөвлөлт хийж байгаа гэж үзэхгүй байгаа бөгөөд эдгээр үйл ажиллагааны төлөвлөгөөг УХА-ЭМЯ-ны ажил гэж төсөл дээр тусгасан байна.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТББ	<p><b>Б.Мягмар:</b> Илүү тодорхой байдлаар тайлбарлана уу. ЭМС-ын 186 дугаар тушаалыг ЭМЯ-ны мэргэжилтэн Д.Баярмаа танилцуулах байсан боловч гишүүдийн саналаар ХЗН-тэй хамтран ажиллаж нэгтгэн сайжруулсан байдлаар засварлан ирүүлэх шаардлагатай. Энэхүү асуудлыг хурал дээр ирж нэг бүрчлэн тайлбарлах нь хурлыг сунжруулж байна. Тиймээс та бүхэн яаралтай хамтран ажиллаж нэгдсэн саналд хүрэх хэрэгтэй. 2018 оны 6 сарын 4 гэхэд ҮЗЗ-ийн ажлын албанд хурлын хөтөлбөрт оролцуулах талаар саналыг ирүүлэх хэрэгтэй.</p>
ХЗН	<p><b>А.Оюунбилэг:</b> 2018-2020 онд хэрэгжүүлэх Сүрьеэгийн төслийн сорьц тээвэрлэх үйл ажиллагааг хийдэг ТББ-ын ажил байна. Энэ байгууллага нь олон жил энэ сорьц тээвэрлэх үйл ажиллагааг хийсэн бөгөөд ажлын үр дүн сайтай, олон ч сүрьеэтэй өвчтөнг илрүүлж оношилсон. Гэтэл энэхүү сайдын тушаалыг ХЗН-тэй зөвлөлдөлдөггүйгээр гаргасан байна. Түүнчлэн энд бичигдсэн Интервенци 7.1: Зорилтот бүлгийн хүн амын дунд Халдварт бус болон халдварт өвчний хавсарсан илрүүлгийг явуулын үйлчилгээ ашиглан зохион байгуулах 67,569.0 ам.доллар манайд орж ирээгүй. Энэ нь ханган нийлүүлэлтийн буюу ГС зохих байгууллагад шилжүүлэн тоног төхөөрөмжийг тухайн улсад ирүүлдэг журмын дагуу орж ирэх санхүүжилт юм. Энэ санхүүжилтэнд 1300 ш Genexpert-ийн оношлуур, ЭХО, ЭКГ буюу зүрхний бичлэг хийдэг хавсарсан 2 ширхэг аппарат авахаар төлөвлөсөн. Тиймээс дахин хэлэхэд энэ мөнгө нь ГС-д байгаа ханган нийлүүлэлтийн санхүүжилт юм. Тиймээс нийт 105000 ам.долларын 67569 ам. доллар нь манайд орж ирээгүй.</p> <p>Түүнчлэн энэхүү танилцуулга дээр маш олон хууль зөрчсөн мэтээр ярьж байгааг нь гайхаж байна. Энэ төслийг мэргэжлийн олон байгууллагууд ажлын хэсэгт оролцон, удаа дараа хуралдаж, хамтран боловсруулсан бөгөөд ҮЗЗ батлан ГС-д өргөн барьсан. Түүний дараа ГС-д төслийн техникийн хөндлөнгийн хяналтын хороо шалган, төслийг батлах комисс 2 удаа хуралдсан бөгөөд 2017 оны 9 сард Женевт төслийн гэрээний хэлэлцээрээр батлагдсан. Түүний дараа ГС-ын удирдлагын хурлаар батлагдсан Ийнхүү олон шат дамжлагыг дамжин батлагдсан энэ төслийг эхлүүлээд 1 улирал болж байхад дахин төлөвлөлт хийе гэсэн шаардлагыг тавьж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ТББ-аар гүйцэтгүүлж байна гэж байна. Үүнтэй холбогдуулан ЗГ-ын тогтоол болон холбогдох баримт бичгийг судалж үзэхэд ДОХ, сүрьеэ дээр хүний нөөц 40%-ын дутагдалтай байгаа бөгөөд ЗГ-ын хүрэхгүй байгаа газруудад бид ТББ-ын тусламжтайгаар хүрч ажиллаж байна. Түүнчлэн ЗГ-ын 121 дүгээр тогтоолд энэхүү ажлыг мэргэжлийн холбоод хийх шаардлагатай гэсэн байна. Тиймээс үүнийг Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо гүйцэтгэж байгаа нь мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй.</li> <li>• Бас нэгэн тодорхой бус асуудал байна. Түүнчлэн ЭМС-ын тушаалыг хүндэтгэн үзэж байна. Үүн дээр Ерөнхий сайд ДОХ, сүрьеэгийн асуудлыг өөрийн ивээл доор авья гэсэн бөгөөд үүний хүрээнд УИХ-ын 8 гишүүний бүрэлдэхүүнтэй “Сүрьеэгүй Монгол” гэсэн лобби бүлэг байгуулан ажиллаж байна. Ерөнхий сайдын зөвлөх түүвэрлэн авсан 6 газар сүрьеэгийн илрүүлэх үзлэгийг хийж байгаа, урьдчилсан байдлаар 22000 хүнийг илрүүлэх үзлэгт хамруулж байна. Энэ тушаалд газруудад дээрх санхүүжилтыг тарааж өгье гэсэн байна. Үүнд үлдсэн 38000 ам.доллар хүрэлцэх үү. Урд нь сүрьеэгийн тархалтын судалгаа, илрүүлэг, оношлогоо, эмчилгээ 50000 хүнд хийхэд 1200000 ам.доллар зарцуулсан. Гэтэл энэ санхүүжилт юунд нь зарцуулах талаар болон хангалттай хүртээмжтэй байна уу гэдэгт та бүхэн анхаарлаа хандуулах хэрэгтэй гэдгийг хэлэх байна.</li> </ul> <p>Тоног төхөөрөмж авах 67569 ам.долларыг ГС-аас хүсэхдээ бид үзлэг хийх болсон тиймээс санхүүжилтыг хүлээн авья гэсэн шийдвэрийг гаргах болоод байна.</p>
ТББ	<p><b>Б.Мөнхцэцэг:</b> Интервенци 1.4, Интервенци 7.1, Интервенци 7.3.1-ийн нийт 105887,5 ам.долларыг 21 аймаг, 6 дүүрэг ХӨСҮТ-д хуваарилж байгаа юм байна. Гэтэл төлөвлөсөн, батлуулсан зорилтдоо хэрхэн хүрэх вэ? Яг юуг үндэслэн энэхүү тушаалыг гаргасан бэ? 2018 оны 4 сарын 4-нд тушаалаа гаргачихаад одоо бид нараар батлуулах гээд байгаа хэрэг үү? Тайлбарлаж өгнө үү.</p>
ТБ	<p><b>А.Өнөржаргал:</b> Ер нь бол ҮЗЗ-ээс энэ тушаалыг хэлэлцүүлэе гэдэг албан бичгийг бидэнд ирүүлсэн болохоор бид энд танилцуулаад байж байна. Түүнээс бус бид одоо энэхүү тушаалыг илгээн ХӨСҮТ мэргэжил арга зүйгээр ханган, тухайн орон нутагтаа эрсдэлт бүлэг, алт олборлогч эсвэл сумыг сонгох эсэх холбогдох шийдвэрээ гарган нарийвчилсан төсөв, төлөвлөгөөг боловсруулан батлуулах чиглэлтэй байгаа. Энэ асуудлыг бид ҮЗЗ-д явуулсан албан бичигтэй тодорхой дурдсан.</p> <p>А.Оюунбилэг даргын хэлсэн тэр Байнгын хороон дээр гарсан асуудлаар Байнгын хорооноос бидэнд ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг үндэслээд ЭМ-ийг дэмжих сангаас гаргах чиглэл өгсөн учраас дээрх 22000 хүний үзлэгийг санхүүжүүлэх болсон.</p> <p>Энэ тушаалыг ҮЗЗ-д танилцуул гэсэн албан бичиг ирсэн үүргийн дагуу энд танилцуулж байна.</p>
Ажлын Алба	<p><b>Б.Оюундарь:</b> Эрүүл мэндийн сайдын А/126 тоот тушаалын талаар Глобал сангийн манай улсыг хариуцсан менежер Манаб Баснетад ХЗН танилцуулсан. Уг хүсэлтийн дагуу 2018 оны 4 сарын 23-нд дараах хариулт ирсэнийг уншиж танилцуулья. Үүнд:</p>

	<p>Цаашид, Эрүүл мэндийн яам болон бусад оролцогч талуудад хандан хэлэхэд та бүхэн буцалтгүй тусламжийн батлагдсан гэрээ, түүний санхүүжилтийн журмын дахин төлөвлөлт хийх удирдамжинд анхааралаа хандуулахыг хүсэж байна. Оролцогч талууд болон хэрэгжүүлэгчдээс ирүүлэх бүх дахин төлөвлөлтөнд, энэ удаагийн (ирээдүйд) хүсэлтэд ч мөн хамааралтайгаар, би дараах зөвлөмжийг хүргүүлж байна:</p> <p>a) Санал болгож буй төсвийн тодотголууд нь үндэсний хөтөлбөрийн бодит байдалд хэрхэн нийцэж байгааг үнэлэх. Гол суурь асуулт нь: Өөрчлөлт хийх хүсэлт нь Глобаль сангийн төслийн агуулагатай тохирч байгаа эсэх? Харилцан зөвшилцсөн төсвийн хүрээнд үү? Хэрэгжилтийн хуваарийн хүрээнд үү? Хэрэгжилтийн зураглалын хүрээнд үү? Өвчлөлийн бүртгэгдсэн байдлыг харгалзаж үзсэн үү (аймгаар)?</p> <p>b) Хоёрдугаарт, дахин төлөвлөлт хийх шалтгааныг үндэслэлтэй эсэхийг тодруулж үнэлэх. Үнэлгээнд хамрагдах зарим гол асуулт / үзүүлэлтүүдийг доор жагсаав:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стратегийн хөрөнгө оруулалт хийх шаардлага байна уу? Жишээ нь: Үндэсний стратеги төлөвлөгөө, өвчлөлийн тархвар зүйн чиг хандлагад өөрчлөлт орсон эсэх, үндэсний хэмжээний судалгаанаас шинэ мэдээлэл гарсан эсэх эсвэл хөтөлбөрийн үнэлгээ болон ДЭМБ-аас Монгол улсад зориулан гаргасан зөвлөмж байгаа эсэх?</li> <li>- Шинжлэх ухааны шинэ нотолгоо бий болсон эсвэл норматив заавар байна уу?</li> <li>- Үндэсний нөхцөл байдалд өөрчлөлт (зөвшөөрөгдсөн) орсон уу?</li> <li>- Нэгж үнийн болон төсвийн өөрчлөлт болсон уу?</li> <li>- Хэрэгжүүлэлтийн хуваарьт өөрчлөлт хийгдсэн үү?</li> <li>- Үр дүнтэй интервенцийг өргөжүүлэх гэж байна уу?</li> </ul> <p>Өөрчлөлт хийх хүсэлтийг Глобаль санд илгээхийн өмнө ҮЗЗ-д хүсэлтээ тавих нь зүйтэй. Мөн зардлын нэгж задаргаа, тооцоолол болон бусад холбогдох хүчин зүйлсийг тодруулах нь чухал юм. Сайдын тушаалыг би бүрэн хүндэтгэж байна. Гэсэн хэдий ч, Глобаль сангийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлтийн хувьд, сайдын бүх тушаалууд нь дээр дурьдсан параметруудийг шийдвэрлэх, мөн төсөлд дахин төлөвлөлт хийх санхүүжилтийн журмыг мөрдлөг болгосон байх нь зүйтэй.</p> <p>Дээр дурьдсаны дагуу, дахин төлөвлөлт хийх үндэслэл шаардлагаа тодорхой болгосон бол Үндэсний зохицуулах зөвлөлд танилцуулан уу (дахин төлөвлөлтийг ширхэг бүрээр хийхийн оронд нэгдсэн байдлаар санал оруулахыг зөвлөж байна). ҮЗЗ-өөс 2017 онд стратегийг баталж өргөн барьсан учраас энэ нь зайлшгүй юм аа. Бид хэлэлцүүлгийг үргэлжүүлэхийг хүсэж байна.</p> <p>Нэгэнт, ҮЗЗ энэ хүсэлтийг дэмжвэл дахин төлөвлөлтийг Глобаль сангийн загварт оруулан бидэнд илгээнэ үү. Шаардлагатай гэж үзвэл бид СОНА-аар шалгуулж баталгаажуулах болно гэжээ.</p>
МҮЭ	<p><b>Б.Мягмар:</b> Энэхүү захидлыг үндэслэн ЭМЯ-д танилцуулах хүсэлтийг хүргүүлсэн.</p>
ТБ	<p><b>Б.Цогтбаатар:</b></p> <p>1. Интервенци 7.1-д санхүүжилт нь ирээгүй ханган нийлүүлэлт-тоног төхөөрөмжийн зардал юм байна. Гэтэл үйл ажиллагаан дээрээ зорилтот бүлгийн хүн ам, халдварт болон халдварт өвчний хавсарсан илрүүлгийг явуулын үйлчилгээ ашиглан зохион байгуулах үйл ажиллагаа гэжээ. Энд мэдээллийн зөрүүтэй байдал байна уу? Энэ яг үйл ажиллагааны зардал уу? эсвэл ханган нийлүүлэлтийн төлөвлөгөөн дээр энэ багажийг тэдээр авна гэж тусгасан ажил уу? Хэрэв тийм тохиолдолд ажлын төлөвлөгөөн дээр яагаад үйл ажиллагааны зардал гэж тусгасан бэ?</p> <p>2. Халдварт өвчний үндэсний хөтөлбөр 2017 оны 1 сард батлагдсан. Түүнээс хойш тун удалгүй батлагдсан төсөл байна. Тэгэхээр нийт хэдий хэмжээний төсөвтэй төсөл болвруулсан бэ? Үүнд эрт илрүүлгийн чиглэлээр төсвийн боломж хэдий хэмжээтэй тавигдсан бэ?</p>
ХЗН	<p><b>А.Оюунбилэг:</b> ДОХ, сүрьеэгийн төслүүд дээр ГС-аас өгч буй зөвлөмжийн дагуу болон Үндэсний хөтөлбөрт тусгагдсан зүйлс бол нэн тэргүүнд эрсдэлт бүлгийн хүн амруу хандсан үйл ажиллагааг явуулахыг заасан байдаг. Тиймээс эдгээр явуулын тоног төхөөрөмжийг ашиглан эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэгийн эрт илрүүлэг хийх үйл ажиллагаа юм. Эрт илрүүлэгт ашиглах явуулын оношлогооны аппарат гэсэн нэртэй байгаа. ГС-ын санхүүжилтын журам дээр энэ төсөл Үндэсний хэмжээнд өргөн барьж буй төсөл тэр утгаараа ҮЗЗ өөрөө батлан өргөн барьсаны хувьд дахин төлөвлөлтийг заавал ҮЗЗ-д танилцуулж батлуулсан байх ёстой гэсэн журмаараа л энэ шаардлагыг ГС тавьсан.</p> <p>Санхүүжилтын журам дээр тухайн интервенцийн 15% доторх өөрчлөлтийг ГС-аас зөвшөөрөл авахгүйгээр төслийн зохицуулагч өөрийнхөө хүрээнд шийднэ гэсэн байдаг. Гэтэл энэ 15%-аас давсан учраас заавал ҮЗЗ батална гээд заасан байдаг. Түүний дагуу л явж байна.</p>

	Түүнчлэн санхүүжилтын журмын дагуу улс орнууд өөрийн хэмжээнд гэнэт урган гарсан нөхцөл байдалтай холбоотойгоор дахин төлөвлөлтийг хийж болно. Гэхдээ жилд 1 удаа хийх хэрэгтэй гэсэн байдаг. Гэтэл одоо төслийн үйл ажиллагаа эхлээд нэг л улирал өнгөрч байхад дахин төлөвлөх асуудал оруулах нь хэр зохимжтой вэ?
ҮАБЗ	<b>Ж.Мөнхжаргал:</b> Бид ЗГ-ын гишүүн ЭМС-ын тушаалыг хэлэлцэхгүй, харин танилцлаа. Манай ҮЗЗ-ийн ажлын албаны саналын дагуу хүрэлцэн ирж танилцуулсанд талархаж байна. Гэхдээ “Дэмжих сангаас” хэрэгжүүлэх гэж байгаа эрт илрүүлгийн аймаг дүүргүүдийн төсвийг хасаад, одооны яригдаж буй дахин төлөвлөлтийн асуудлыг шийдэх саналтай байна.
ТББ	<b>Б.Мягмар:</b> Бид бүсийн менежерийн ирүүлсэн зөвлөмжийн дагуу дахин төлөвлөлтийн асуудалтай танилцаад явж байна. Гэтэл одоо бас ЭМС-ын а/186-р тушаал гээд урьдчилж танилцуулагдаагүй тушаал байгаа бөгөөд энэхүү асуудлыг одоо энд хэлэлцээд суух нь хэр зүйтэй болох вэ? Өнөөдрийн хувьд ҮЗЗ-д ЭМС-ын 126 тушаалыг танилцуулна гэж хөтөлбөрт оруулсан байна. Тиймээс ЭМЯ дахин төлөвлөлтийг хийх гэж байгаа бол ҮЗЗ-ийн зүгээс дэмжин ХЗН-ийн мэргэжилтнүүдтэй хамтран нэгтгэж оруулж ирэхийг хүсэж байна. Тиймээс ҮЗЗ-д шинээр орж ирсэн ЭМЯ-ны 2 гишүүн маань манлайлан энэхүү дахин төлөвлөлтийн асуудлыг төслийн хүрээнд бүрэн боловсруулж ирнэ үү гэсэн саналыг дэвшүүлэх байна.
ХЗН	<b>С.Ганзаяа:</b> Түрүүн Б.Цогтбаатар даргын асуултанд хариулахад энэ 67569 ам.доллар бол сүрьеэгийн төслийн Нэгдсэн тусламж үзүүлэх дэд бүтцийг сайжруулах модулийн хүрээнд орсон үйл ажиллагаа юм. Тиймээс энэхүү төсөв нь тухайн интервенцийн 32%-ийг эзэлж байна. ГС-ын дахин төлөвлөлт хийх журмын дагуу хэрвээ интервенцийн 15%-иас хэтэрвэл дахин төлөвлөлт хийх ёстой. Түүнчлэн Манабын ирүүлсэн захидлаас харахад ГС-ын төсөл боловсруулахад нарийвчилсан задаргаа байдаг гэдгийг дурдсан байсан. Мөн биднийг энэхүү төслийг боловсруулж байхад ЭМЯ-ны зүгээс энэ төсөл сүүлийн төсөл байх магадлалтай учраас нийт санхүүжилтын 62%-ыг тоног төхөөрөмж худалдан авах зардалд зарцуулах санал гаргасан. Тэгсэн атлаа одоо худалдан авалтыг үйл ажиллагаа болгох санал тавьж байгаа нь төсөл эхлээд дөнгөж 1 улирал өнгөрч байхад энэ саналыг гаргаж байгаа нь Монгол улсын хувьд зохимжгүй харагдах болов уу гэж бодож байна. Түүнчлэн энэ саналын дүнгүүд бүхэл дүнгээр тавигдсан байна. Жишээлбэл: ХӨСҮТ 14 сая төгрөг гэсэн байна. Түүгээр ХӨСҮТ яг юу хийх гэж байгаа вэ? Хаана ажиллах гэж байна вэ? Үүний оронд ХӨСҮТ байгаа рентген аппаратаа засуулах хүсэлтийг яагаад тавихгүй байна вэ? Өнгөрсөн хугацаанд 6 ширхэг рентген аппарат авсанаас одоо нэг нь ч ажиллахгүй байна гэсэн хүсэлт тавиад байгаа.
НҮБ	<b>А.Цэцэгмаа:</b> Би ОУБ-ыг төлөөлөн энэхүү хуралд сууж байгаагийн хувьд ойлгохгүй байгаа зүйл надад байна. Аливаа ОУБ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тухайн улс оронд ямар бэрхшээлтэй, шийдвэрлэвэл зохих асуудлууд байгааг харгалзан түүнд нь зохих төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, хөрөнгө, санхүүжилт олгодог. ОУБ-ын хөрөнгө, санхүүжилт төлөвлөх үйл явц нь маш нарийн зохион байгуулалттай, нэгэнт төлөвлөсөн санхүүжилтыг өөрчлөхөд хэцүү байдаг. Гэхдээ эдгээр ОУБ-ын төслүүдийн зорилго бол ЗГ-ын хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан ЗГ-тай зөвлөлдөн, уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж боловсруулсан төсөл гэж ойлгодог. Би ҮЗЗ-ийн хуралд 3 дахь удаагаа оролцож байгаа бөгөөд ХЗН болон ЭМЯ нь нэг асуудлыг шийдвэрлэхээр бус 2 тал болоод байгаа нь ерөөсөө ойлгогдохгүй байна. Энэ байдлыг маш хурдан засаж, ХЗН, ЭМЯ-тай хамтран ажиллаж асуудлыг хурлаар хэлэлцүүлэхээс өмнө тохирч, шийдвэрийн гаргалгааг олж эцсийн шийдвэрийг энд оруулж ирж танилцуулж байх ёстой. Энэ байдал ямар ч үр дүнд хүргэхгүй. Бие биеийнхээ ажлыг уяж, хойш татсан байдалд хүргэж байна. Гэтэл ОУБ энэ санхүүжилтыг ЗГ-ын зорилгоос өөр зүйлд зарцуулж, өөр чиглэлд хэрэгжүүлэн, өөр үр дүнд хүрэх гэсэн асуудал байхгүй. Тэгэхээр энэ асуудлыг анхааран ажиллаж, хурлыг эрчимтэй, үр дүнтэй явуулахад анхаарах хэрэгтэй гэдгийг хэлмээр байна. Асуудлыг шийдэх бололцоо байвал цаг алдалгүй шийдэх хэрэгтэй.
ХЗН	<b>А.Оюунбилэг:</b> Монгол улсын Үндэсний хөтөлбөр дээр тусгагдсан зүйлсийг л энэ төсөлд оруулсан бөгөөд 150 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Үндэсний хэмжээний зөвшилцөх уулзалт зохион байгуулж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон. Түүнчлэн төсөл боловсруулах ажлын хэсэгт 17 байгууллагын төлөөлөл 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 21 удаа хуралдаж энэ төслийг боловсруулахад ЭМЯ ч бүрэлдэхүүнд нь байсан. Тэгэхэд одоо 9 аймагт хийх байсан үзлэгийн санхүүжилтыг үндэсний хэмжээний бүх аймаг, дүүргүүдэд хуваах санаа гаргаад байгаа юм. Энд ганц эргэлзээтэй асуудал байгаа нь тоног төхөөрөмжөө авахаа болиод үзлэгтээ зарцуулах эсэх асуудал байна. Үүнтэй холбоотойгоор ЭМЯ-наас ХӨСҮТ-ийн 1-р улирлын хүсэлтийг огт баталгаажуулж өгөөгүй байна. Үүнээс үүдэн энэ байгууллагын төлөвлөгөөт үйл ажиллагаа бас гацаж, хүлээгдээд байна.
Хүүхэд, залуусын байгууллага	<b>А.Нямдорж:</b> Зарчмын хувьд энд зөрчил харагдаад байна. Энэ нь ҮХА үүнийг дахин төлөвлөлт биш гэж үзээд, үндсэн ажлаа л зохицуулж байна гэж байна. Харин ХЗН энэ бол яах аргагүй дахин төлөвлөлт гэж байна. Гэтэл бид юунд үндэслэн хэрхэн шийдвэр гаргах нь эргэлзээтэй болоод байна. Үүнийг бид ГС-ын ҮЗЗ-ийн журмын дагуу ажиллаж байна гэдгийг л нотлох ёстой. Тэр ч утгаараа энд СОНА-ын төлөөлөл ажиглаад сууж байна. Тиймээс үүнийг бид хэрхэн шийдвэрлэх ёстой вэ? Энэ дахин төлөвлөлт мөн үү? Эсвэл биш юм уу? Түүнчлэн бид ХӨСҮТ-ийн тоног төхөөрөмжийг авна эсвэл авахгүй гэдгийг бид өнөөдөр шийдэх эрхтэй хүмүүс мөн үү? Энэ төслийг анх бичихдээ л томьёолоод явсан түүнийхээ дагуу л явж байгаа. Гэтэл энэ 67569 ам.долларыг хэрхэн шийдэх вэ? Энэ асуудлыг ЭМЯ ХЗН-тай хамтран маш хурдан хуралдаад нэг тийш шийдвэрлэх хэрэгтэй. Яг өнөөдөр энэ зөрчилдөөн үүссэн байхад шийдэхэд тохиромжгүй. Эдгээр асуудлууд бүгд чухал гэдгийг ойлгож байгааг та бүхэн бас бодолцоорой гэж хүсэж байна.

ТБ **Б.Цогтбаатар:** А.Цэцэгмаа гишүүн биднийг хөндлөнгийн нүдээр хараад сайн тодорхойлж, зөв зүйл хэлж байна. А.Нямдорж дарга бас үнэнийг хэллээ. Түүрүүн төсвийн задаргаа байх ёстой гэж хэлж байсанчлан ҮХА, ХЗН хамтран тэр задаргааг боловсруулж, энэ хуралд танилцуулах ёстой.

Шийдвэр:  
ЭМЯ-ны мэргэжилтнүүд ЭМС-ын 126 болон 186 дугаар тушаалуудыг ХЗН-тэй хамтран нарийвчлан боловсруулж, нэгдсэн саналтайгаар ҮЗЗ-ийн гишүүдэд дараагийн хурлаар дахин танилцуулж батлуулах эсэх талаар хэлэлцүүлэх үүргийг өглөө. Үүнтэй холбоотойгоор Ажлын албанд ҮЗЗ-ийн 78 дахь хурлыг 2018 оны 6 сарын 8-ны өдөр зохион байгуулахыг үүрэг болгов.

**Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар**

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Төхирөх нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		10
		Эсрэг>		
Санал өгөхөөс түдгэлзэх				

**Хөтөлбөр #4 2018-2020 онд хэрэгжих төслүүдийн Санхүүжилтийн баталгааны болзолт нөхцлүүд**

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)> үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

**М.Сэргэлэн, ХЗН-ийн хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн:** 2018-2020 онд хэрэгжих төслүүдийн Санхүүжилтийн баталгааны болзолт нөхцлүүд /Хавсралт 3/-г танилцууллаа.

**2018-2020 онд хэрэгжих MNG-T-MON and MON-H-MON төслүүдийн Санхүүжилтийн баталгааны болзолт нөхцлүүд.**

N	Боловсруулах бичиг баримтууд	Хариуцах байгууллага	Биелүүлэх хугацаа	Ажлын явц
1	Тогтвортой байдал, шилжилтийн төлөвлөгөө	ҮЗЗ, ЭМЯ, ХӨСҮТ	2019.03.01	Эрүүл мэндийн яам бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбоотой Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, зарим газар хэлтсийн дарга нар солигдсон тул шилжилтийн төлөвлөгөө боловсруулах асуудлыг дахин танилцуулах ажлыг ҮЗЗ-ийн зүгээс манлайлан зохион байгуулах шаардлагатай. Хэрэгжүүлэх шатны байгууллагууд харьцангуй мэдээлэл сайтай байна. Глобаль сангийн зүгээс техникийн туслалцаа авахыг ХЗН-ийн зүгээс санал болгож байна.
2	ДОХ, сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээний ХШҮ-ий Үндэсний төлөвлөгөө	ЭМЯ, ХӨСҮТ	2018.03.31	ЭМЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтэнүүд “ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн төлөвлөгөөг” боловсруулаад дуусч байна. Дараа нь сүрьеэгийн ХШҮ-ний төлөвлөгөөг боловсруулна.
3	GeneXpert-ийн оношлогоог өргөжүүлэх төлөвлөгөө	ЭМЯ, ХӨСҮТ	2018.10.31	ЭМЯ-ны лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн өөр ажилд шилжсэнтэй холбоотой төлөвлөгөө боловсруулах ажил зогсоод байна.

4	Хүний нөөцийн стратеги-	ЭМЯ, ХӨСҮТ	2018.12.31	Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгээр боловсруулагдаж буй 2019-2027 онд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөнд хүний нөөцийн асуудал тусгагдах тул тусдаа стратеги байх шаардлагагүй гэж үзсэн.
5	Эрүүл мэндийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлттэй холбоотой Үйл ажиллагааны стандарт аргачлал	ЭМЯ, ХӨСҮТ	2018.05.31	Аргачлалыг Дэлхийн эм ханган нийлүүлэх байгууллагын зөвлөх боловсруулж ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн эмийн менежментийн багийн хурлаар хэлэлцүүлсэн. Эцсийн байдлаар батлагдаагүй байна.
6	Сүрьеэгийн тусламж үйлчилгээ болон хяналтад төр хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох удирдамж	ЭМЯ, ХӨСҮТ	2019.01.01	Эхлээгүй.
7	Салбар хүлээн авагчийн менежментийн гарын авлага	ХЗН	2018.03.31	Өмнө нь ХЗН-ээс гаргасан ХШҮ-ний, санхүүгийн, ханган нийлүүлэлтийн гарын авлагууд дээр суурилан боловсруулж байна.

Шийдвэр:

**Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар**

Зөвшилцөл	<input checked="" type="checkbox"/>			
Санал хураалт	<input checked="" type="checkbox"/>	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

**Хөтөлбөр #5** Эрүүл мэндийн салбарын засаглалыг бэхжүүлэх хүрээнд ХДХВ, сүрьеэгийн төслийг нэгдсэн зохицуулалтаар хангах техникийн туслалцаа, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардлагатай төсвийн төслийг боловсруулах

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

**Ч.Оюун:** Эрүүл мэндийн салбарын засаглалыг бэхжүүлэх хүрээнд ХДХВ, сүрьеэгийн төслийг нэгдсэн зохицуулалтаар хангах техникийн туслалцаа, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардлагатай төсвийн төслийг боловсруулах /Хавсралт 4/ тухай танилцуулгыг хийлээ.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Хариулт:

Шийдвэр:



<b>Хөтөлбөр #6</b>	<ul style="list-style-type: none"> <li>Салбар хүлээн авагчийн танилцуулга: ХӨСҮТ-ийн Сүрьеэ болон БЗДХ-ийн ТСА-ны төслүүдийн хэрэгжилтийн танилцуулга</li> </ul>			
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.				
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>				Тийм
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй				
<b>Салбар хүлээн авагчийн танилцуулга:</b> ХӨСҮТ-ийн Сүрьеэ болон БЗДХ-ийн ТСА-ны төслүүдийн хэрэгжилтийн танилцуулга хийх байсан боловч хурлын хөтөлбөрийн хугацаа хэтэрсэн тул Д.Энхмандах тус хурлын дундуур дараагийн ажилдаа явах чөлөөг хүссэнээр энэхүү асуудлыг ээлжит хурлаар танилцуулах боллоо.				
<b>Шийдвэр:</b>				
<b>Салбар хүлээн авагчийн танилцуулга:</b> ХӨСҮТ-ийн Сүрьеэ болон БЗДХ-ийн ТСА-ны төслүүдийн хэрэгжилтийн танилцуулгыг ҮЗЗ-ийн гишүүдийн саналаар ҮЗЗ-ийн 78 дахь хурал дээр танилцуулахаар хойшлууллаа.				
<b>Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар</b>				
Зөвшилцөл	x			
Санал хураалт	x	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	x
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		13
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		
<b>Бусад:</b>	ҮЗЗ-ийн санхүүжилтийг хүлээн авах тухай			
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.				
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>				Тийм
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй				
<b>А.Нямдорж:</b> ҮЗЗ-ийн санхүүжилтийг ЭМЯ-ны нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авдаг явдал нь ЭМЯ-нд маш их ачаалал өгдөг тухай албаныхан өмнө албан ёсоор мэдэгдэж байсан. Үүний дагуу ЭМЯ-ны СЭЗГ-ын даргатай уулзаж ҮЗЗ-ийн санхүүжилтийг өмнө хүлээн авч байсан урсгалаар авах хүсэлтийг тавьсан ба ингэхдээ ГС-гийн бусад улс орнуудад зөвшөөрдөг зарчмыг баримтлан нягтлан бодогчтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллах тухай санал болгож харилцан тохиролцов.				
<b>Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар</b>				
Зөвшилцөл	x			
Санал хураалт	x	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	x
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		13
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		
<b>ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ</b>				

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#2	1. Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар ҮЗЗ-ийн дүрмийг бүлэг бүлгээр нь хэлэлцэн, санал хурааж эцэслэн баталлаа. 2. ҮЗЗ-ийн дарга, дэд дарга, гүйцэтгэх хороо, хяналтын хорооны бүтэц бүрэлдэхүүний асуудлыг ҮЗЗ-ийн 78 дахь удаагийн хурлаар эцэслэн шийдвэрлэхийг гишүүдийн саналаар түр хойшлуулав.	АЖЛЫН АЛБА, ҮЗЗ-ийн гишүүд	
хөтөлбөр#4	ЭМЯ-ны мэргэжилтнүүд ЭМС-ын 126 болон 186 дугаар тушаалуудыг ХЗН-тэй хамтран нарийвчлан боловсруулж, нэгдсэн саналтайгаар ҮЗЗ-ийн гишүүдэд дараагийн хурлаар дахин танилцуулж батлуулах эсэх талаар хэлэлцүүлэх үүргийг өглөө. Үүнтэй холбоотойгоор Ажлын албанд ҮЗЗ-ийн 78 дахь хурлыг 2018 оны 6 сарын 8-ны өдөр зохион байгуулахыг үүрэг болгов	ҮХА-ЭМЯ, ХЗН, АЖЛЫН АЛБА	
хөтөлбөр#6	<b>Салбар хүлээн авагчийн танилцуулга:</b> ХӨСҮТ-ийн Сүрьеэ болон БЗДХ-ийн ТСА-ны төслүүдийн хэрэгжилтийн танилцуулгыг ҮЗЗ-ийн гишүүдийн саналаар ҮЗЗ-ийн 78 дахь хурал дээр танилцуулахаар хойшлууллаа.	ХӨСҮТ, Д.Энхмандах	

#### ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	2018 оны 6 дугаар сар
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	


#### БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү)


	Тийм	Үгүй	
Хурлын төв, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

#### ТОВЧИЛСОН ҮГ:

Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл

ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
УХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

<b>БАТАЛСАН:</b>			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2018 оны 6 сарын 5
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

<b>ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:</b>			
Нэр>	Б.Оюундарь,	Огноо>	2018 оны 6 сарын 5
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

<b>ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:</b>			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2018 оны 6 сарын 5
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	